

## ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХӨРВҮҮЛЭЛТ БОЛОН БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

### Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот  
2020.10.13

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ” эсвэл “EBRD”)-аас авсан \$5 сая америк долларын хөрвөх нөхцөлтэй зээлийн хүрээнд ЕСБХБ нь хөрвүүлэх эрхээ хэрэгжүүлснийг мэдээлж байна. Дээрх хөрвөх боломжтой зээлийг хувьцаанд хөрвүүлсний үндсэн дээр ЕСБХБ нь 30,043,290 энгийн хувьцааг эзэмшсэнээр Компанийн гаргасан болон арилжигдаж буй нийт энгийн хувьцааны 11.2%-ийг эзэмшинэ.

Мөн Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд оршдог өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Баян Хөндий Алтны Төслийн (“Баян Хөндий” эсвэл “БХ”) тухай танилцуулга хийлээ.

### Компанийн тодруулга:

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “ЕСБХБ-ны хөрвөх нөхцөлтэй зээлийн санхүүжилтээр Баян Хөндий Алтны Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг эцэслэсэн. ЕСБХБ-ны хөрвүүлэлт болон ноён Эрик Спроттын \$15 сая канад долларын хөрөнгө оруулалт бүхий \$20 сая канад долларын санхүүжилт нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэхэд шаардлагатай төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Компани нь 2022 онд алтны үйлдвэрлэлтийг эхлүүлэхээр төлөвлөн, Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлж, дүүргийн хэмжээнд нөөц нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна.”

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Байгалийн нөөцийн салбар хариуцсан захирал Эрик Рассмуссен (“Eric Rassmussen”): “Бид Монгол Улсын баруун өмнөд бүсэд оршдог Баян Хөндий Алтны Төслийн үр өгөөжийг батлан харуулсан эдийн засаг, техник, байгаль орчин болон нийгмийн судалгаануудыг дэмжин ажилласандаа баяртай байна. Зээлийг үнэт цаасанд хөрвүүлснээр Баян Хөндий Алтны Төсөлд өөрсдийн оролцоог хадгалахаас гадна нийт оролцогч талуудад үр ашигтай төслийг дэмжиж байгаадаа баяртай байна.”

### ЕСБХБ-ны Монгол дахь үйл ажиллагааны тухай

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”) нь Монгол Улс дахь хамгийн том гадаадын хөрөнгө оруулагчдын нэг. Өнөөг хүртэл ЕСБХБ нь Монгол Улсын эдийн засгийн бүхий л салбарт 1.8 тэрбум евро (2.8 тэрбум канад доллар)-ийн хөрөнгө оруулалтыг 113 төсөлд хийснээс дийлэнх нь хувийн хэвшилд оруулсан хөрөнгө оруулалт байна. ЕСБХБ нь Монгол Улсын хувийн хэвшил болон дэд бүтцийн салбарын олон талт, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэн ажилладаг.

## Хөрвөх боломжтой зээлийн тухай

2019 оны 10 сарын 11-нд үзэглэсэн хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээний хүрээнд ЕСБХБ нь Эрдэнэ Ресурсд 5.0 сая америк доллараар санхүүжүүлт хийсэн. 2020 оны 10 сарын 9-нд ЕСБХБ нь хөрвүүлэх опционоо хэрэгжүүлэн, Хөрвөх боломжтой зээлийн нийт үнийн дүнг хувьцаанд хөрвүүлж, 30,043,290 энгийн хувьцаа буюу Компанийн гаргасан болон арилжигдаж буй нийт энгийн хувьцааны 11.2%-ийг эзэмшихээр болж байна. Түүнээс гадна Хөрвөх боломжтой зээлийн гэрээг эцэслэхэд хүүгийн төлбөр болох \$457,639 америк долларыг төлж барагдуулна.

ЕСБХБ-ны Хөрвөх боломжтой зээлийн хөрвүүлэлт болон Баян Хөндий Алтны Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж гүйцэтгэснээр Эрдэнэ Ресурс нь төслийн санхүүжилтийг эцэслэхэд чиглэн ажиллана. Урьд нь мэдээлж байсанчлан компани нь төслийн санхүүжилтийн зөвлөхөөр “HCF International” компанитай хамтран ажиллаж байгаа бөгөөд “HCF International”-ийн гол үүрэг нь Төслийн зээлийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд оршино. “HCF International” нь Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүн болон мөнгөн урсгалын төсөөлөлд тулгуурлан уул уурхайн санхүүжилтийн чиглэлээр ажилладаг санхүүгийн байгууллагуудтай хэлэлцээр хийж байна.

## Баян Хөндий Алтны Төслийн тухай

Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг 2020 оны 3-р улиралд эхлүүлсэн бөгөөд үүнд:

- 2020 оны 4-р улирлын сүүлээр гүйцэтгэж дуусахаар нүүрсэнд уусгах технологийн боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан загварчлал болон инженерчлэлийн ажил болон уурхайн дэд бүтцийг дэмжих ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.
- Бүтээн байгуулалтын төсвийн оновчлолыг гаргахаар голлох байгууламж болон үйлчилгээний тендер, гэрээний ажлууд хийгдэж эхэлсэн.
- Бүтээн байгуулалт, инженерчлэл, эрсдэлт-үйл ажиллагааны (“HAZOPS”) судалгааны үнэлгээ хийгдэж байна.
- Монгол Улсын хууль журамд нийцсэн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”)–ний хэлэлцүүлгийг 2020 оны 4-р улиралд гүйцэтгэн, зөвшөөрөл авах өргөдлийг хүргүүлнэ.
- Голлох төслийн байгууламжийн нарийвчилсан техникийн зургийг боловсруулсан.
- Уурхайн дэмжих байгууламжууд болох оффис, ээлж солих байр, харуул хамгаалалтын байр, үйлдвэрийн цех, агуулах болон хотхоны зургийг боловсруулж дуусан, төслийн ерөнхий зохион байгуулалтын зөвшөөрлийг авахаар өргөдөл гаргаад байна.
- Техникийн зураг төслийг 2021 оны 1-р улиралд бүрэн дуусгаж хүлээлгэн өгснөөр 2021 оны 2-р улирлаас барилгын ажлыг эрчимжүүлэх боломжтой.

## Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн бөгөөд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд нээн илрүүлсэн Хөндий Алтны Дүүрэгт өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбай багтдагаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

### Урьдчилан анхааруулах мэдээлэл

Хөрвүүлэлтээс өмнө ЕСБХБ нь Компанийн энгийн хувьцааг эзэмшиж байгаагүй. Хөрвөх нөхцөлтэй зээлийн нийт үнийн дүнг хөрвүүлэлт хийснээр 30,043,290 энгийн хувьцаа буюу Компанийн гаргасан болон арилжигдаж буй нийт энгийн хувьцааны 11.2%-ийг эзэмшихээр болж байна. Хөрвүүлэлтийн ханш нь нэгж энгийн хувьцааг \$0.21945 канад доллараар үнэлэн, нийт \$5,000,000 америк долларт тэнцүүлэн хөрвүүлсэн. (\$6,593,000 канад доллар, валютын ханшийг 2020 оны 9 сарын 18-ны Канадын төв банкны ханшаар тооцсон)

ЕСБХБ нь энэхүү энгийн хувьцааг хөрөнгө оруулалтын зорилгоор авсан болно. Зах зээлийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзэж, ЕСБХБ нь Компанийн үнэт цаасыг авах, зарах, хадгалах боломжтой.

Урьдчилан анхааруулах мэдээллийн хувийг Канадын үнэт цаасны зохицуулах хороонд бүртгүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү хэлцэлтэй холбоотой урьдчилан анхааруулах мэдээлэлтэй SEDAR, [www.sedar.com](http://www.sedar.com) дахь Компанийн цахим хуудсаас танилцах боломжтой. Мөн +976 11 317 974 дугаарт Цэрэнрааш овогтой Хангайтай холбогдон хүлээн авах боломжтой. ЕСБХБ-ны төв оффис нь ИБУИНВУ-ын Лондон хот, EC2A 2JN, One Exchange Square-д байрладаг.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

### ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

#### Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>